

**Үйлчилгээний
худалдаа ба
Монгол улсын
дижитал эдийн
засгийн
статистикийн
семинар**

**Улаанбаатар
2023 оны 3 дугаар
сарын 20-23**

Дэд хурал 9

**Олон улсын үйлчилгээний
худалдааны статистик (ОУҮХС)-ийн
мэдээлэл цуглуулах: олон улсын
зөвлөмжийн тойм**

Тьерри Кулет

Агуулга

1. Мэдээлэл цуглуулах үйл явц болон өөр хувилбаруудын тойм
2. Төлбөрийн тэнцлийн бүртгэл ба хариуцагчдыг сонгох
3. Судалгаанд оролцогчдын өгсөн мэдээлэл
4. Мэдээлэл цуглуулах жишээ
5. Аялал жуулчлалын үйлчилгээ

**1. Үйлчилгээний мэдээлэл
цуглуулах үйл явц болон
алтернатив хувилбаруудын тойм**

Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага ба хязгаарлалтууд

Мэдээлэл цуглуулах систем нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага, зардлын хязгаарлалтуудыг тэнцвэржүүлэх шаардлагатай:

- **Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага**
 - Шаардлагатай түвшний дэлгэрэнгүй мэдээллийг хангах:
 - EBOPS ангилал
 - Газарзүйн задаргаа
 - Ханган нийлүүлэлтийн горимууд
 - Эмхэтгэсэн мэдээллийн үнэн зөв, цаг үеэ олсон байдал.
- **Зардлын хязгаарлалтууд**
 - Судалгаанд хамрагдсан талуудын (банк, аж ахуйн нэгж...) зардлыг багасгах.
 - Боломжтой нөөцийг (Төв банк, СХО) харгалзан ТТ-ийн хөрвүүлэгчийн зардлыг багасгах.

Боломжит хувилбарууд

- **Банкуудаар дамжуулан бие даасан төлбөр тооцооны шууд бус тайлан гаргах** (банкууд ОУ-ын гүйлгээний тайлангийн систем буюу ОУГТС)
- **Аж ахуйн нэгжүүдээс шууд мэдээлэх, судалгаа авах**
 - ОУГТС-д хамрагдаагүй гүйлгээний хувьд.
 - Эсвэл банкуудын ОУГТС-ийн өөр хувилбарын хүрээнд.
- **Захиргааны мэдээллийг** зарим үйлчилгээний ангилалд (албан ёсны байгууллагуудын статистикийн дайвар бүтээгдэхүүн) ашигладаг.
- Түнш орнууд болон олон улсын байгууллагууд.

Олон улсын гүйлгээний тайлангийн систем (ОУГТС)

- **« Ерөнхийдөө ОУГТС нь банк, аж ахуйн нэгжүүдээс хувь хүний гүйлгээний түвшний мэдээллийг цуглуулдаг систем юм. ОУГТС нь:**
 - Дотоодын банк, аж ахуйн нэгжийн гадаад дахь банкны дансаар дамжуулан оршин суугч бус этгээдтэй хийсэн бие даасан бэлэн мөнгөний гүйлгээ,
 - Оршин суугч бус-аж ахуйн нэгжүүдтэй компани хоорондын хийсэн дансны гүйлгээ,
 - Хувьцаа (эсвэл төлбөрийн тэнцлийн тойм),
 - Бэлэн мөнгөний бус гүйлгээ».
- **Банкинд суурилсан тайлагналын системийн дагуу банкууд оршин суугчид болон оршин-суугчдын хооронд хийгдсэн бүхий л үйл ажиллагааг өөрийн данс эсвэл харилцагчийн дансаар дамжуулан тайлагнадаг.**
- Валютын бүртгэлийн системээр эхэлсэн

Банкуудын ОУГТС

- **Хамрах хүрээ**
 - Банкны системээр дамжуулан хийж буй бүх үйлчилгээний гүйлгээ нь ерөнхий төлбөрийн тэнцлийн тайлангийн системийн нэг хэсгийн хүрээнд хийгддэг.
- **Хариуцагч талууд**
 - Дотоодын банкууд үйлчлүүлэгчдийнхээ нэрийн өмнөөс (шууд бус тайлагнах)
 - Гүйлгээний кодчилол нь банкны үйлчлүүлэгчдийн өгсөн тайлбартай уялдаатай.
 - Гадаадад данстай эсвэл клиринг ба төлбөр тооцооны системд (хэсэгчилсэн байдлаар шууд тайлагнах) оролцдог резидент компаниудын өгөх нэмэлт мэдээлэл.
- **Хариуцлага**
 - Ихэвчлэн Төв банк
- **Өгөгдлийн хэмжээ**

Банкуудын ОУГТС

- **Статистикийн бүртгэлд тайлагнах ёстой мэдээлэлд дараахь зүйлс орно.**
 - Гүйлгээ хийж буй талын таних дугаар
 - Валютын код
 - Дебит эсвэл кредит (урсгал)
 - Гүйлгээ хийсэн огноо
 - Үндэсний болон гадаад валют дахь дүн
 - Эдийн засгийн код (гүйлгээний мөн чанар)
 - Улсын код
 - Хамтрагч талын таних код

Банкуудын ОУГТС-ийн давуу тал

- **Давуу тал**

- Мэдээллийг цаг тухайд нь, богино хугацаанд эмхэтгэх (M+10, магадгүй сар бүр).
- Банкны тайлангийн иж бүрэн байдал: босго хэмжээнээс дээш бүх бэлэн мөнгөний төлбөр тооцоог оруулна.
- Судалгаанд оролцогчдын тоо хязгаарлагдмал байх ба тэдний тогтвортой байдал (банкууд зуучлагчийн үүрэг гүйцэтгэнэ).
- Зардал хэмнэх мэдээллийн эх сурвалж (хамгийн багадаа валютын хяналтын горимын хүрээнд).

Банкуудын ОУГТС-ын хязгаарлалт

- **Хязгаарлалтууд**

- Их хэмжээний бие даасан гүйлгээг удирдахад хэцүү.
- Компани хоорондын нэгдсэн гүйлгээний эзлэх хувь нэмэгдсэн (нийт кредит болон дебит бүртгэлээс ялгаатай).
- Үнэн зөв байдалд нөлөөлж болзошгүй босгуудыг ашиглах.
- Төлбөр эсвэл төлбөр тооцоогоор хийгдсэн гүйлгээ.
- Үйлчилгээний зүйлийн буруу ангилал.
- EBOPS ангилалтай холбоотой өсөн нэмэгдэж буй төвөгтэй байдал
- Газарзүйн задаргаа (төлбөр тооцоо хариуцсан улс нь гүйлгээ хийсэн улсаас өөр байж болно).

Шууд тайлагнах ба судалгаа хийх

- **Хамрах хүрээ**
 - Бүх үйлчилгээнүүд багтах авч гэхдээ мэдээлэл цуглуулах янз бүрийн хэв маягийг зөвшөөрдөг: тооллого, түүвэрлэлт ба/эсвэл таслах журам,
 - Судалгаанд оролцогч тухайн хүн амд зориулсан бие даасан гүйлгээ эсвэл зорилтот судалгааг бүрэн, шууд тайлагнана.
- **Хариуцагч талууд**
 - Үйлчилгээний чиглэлээр олон улсын гүйлгээ хийдэг аж ахуйн нэгжүүдийн **жишээ**.
 - Аж ахуйн нэгжид суурилсан системүүд нь **сонголт хийх** асуудалтай байдгаараа онцлогтой

Шууд тайлагнах ба судалгаа хийх

- **Хариуцлага**
 - Ерөнхийдөө шууд тайлагналын ерөнхий системтэй бол судалгааны хувьд СХО мөн Төв банк.
- **Өгөгдлийн хэмжээ**
 - **GDR** буюу олон улсын хадгаламжийн бичгийн бие даасан өгөгдөл
 - **Судалгаанд** хамрагдсан тохиолдолд үйлчилгээний зүйлээр болон газарзүйн задаргаа бүхий нэгтгэсэн мэдээллийн тайлан.
- **Урьдчилсан нөхцөл**
 - Өндөр чанартай бизнесийн бүртгэл, түүвэрлэлт, асуулгын загвар гаргах, мөн судалгааны үр дүнг боловсруулахад зохих туршлагатай байх.

Шууд тайлагнах ба судалгаа хийх

- **Давуу тал**

- Шууд гэрээ хийсний үр дүнд мэдээлэл илүү чанартай болдог. Шаардлагатай мэдээллийг (түншүүд, EVOPS-ийн дэлгэрэнгүй мэдээлэл, холбоотой/холбоогүй худалдаа) цуглуулах боломж олгоно.
- Өгөгдөл нь ямар ч байдлаар хийгдсэн байх тухайн гүйлгээтэй холбоотой.

- **Хязгаарлалтууд**

- Хариуцагч компанид зориулсан програм хангамжийг хөгжүүлэх зардал.
- Гүйлгээг тодорхойлоход хэцүү байж болно (импортын тал).
- Боломжит чухал өөрчлөлтүүдийг амжуулж хийхэд цаг хугацааны хувьд бэрхшээлтэй.
- Тайлагнах, эмхэтгэх журамтай холбоотой тусгай ур чадвар, өөрчлөлтүүд нэвтрүүлэх шаардлагатай.

Захиргааны мэдээллийн эх сурвалж

Банкны ОУГТС мэдээлэл цуглуулах системтэй улсууд болон судалгааг ашигладаг улсууд зарим ангиллын хувьд захиргааны мэдээллийг ашигладаг:

- **Гаалийн мэдээлэл** (тээвэр, ачаа тээврийн даатгалын үйлчилгээ).
- **Хөрөнгө оруулалтын зөвшөөрлүүд** (ГШХО ба/эсвэл FATS).
- **Шилжилт хөдөлгөөний талаарх захиргааны мэдээлэл** (Аялал жуулчлал).
- **Төсвийн баримт бичиг** : гадаадад суугаа Элчин сайдын яамдууд болон бусад төрийн байгууллагуудын зардал (Төрийн үйлчилгээ)
- **Гадаадын тусламж** (техникийн тусламжийн үйлчилгээ).

Мэдээлэл цуглуулах систем

- **Голчлон ОУГТС ашигладаггүй аж ахуйн нэгжүүдийн судалгаанд үндэслэсэн**
 - Канад, Ирланд, Их Британи, АНУ
- **Голчлон ОУГТС (банкууд ба/эсвэл судалгааны хязгаарлагдмал хэрэглээ бүхий шууд ОУГТС) дээр үндэслэсэн.**
 - Бразил, Франц, Энэтхэг, Орос
- **Голчлон ОУГТС-ийн хязгаарлагдмал хэрэглээтэй судалгаанууд**
 - Нидерланд

2. Төлбөрийн тэнцлийн бүртгэл ба хариуцагчдыг сонгох

Яагаад төлбөрийн тэнцлийг бүртгүүлэх ёстой вэ?

- ТТ-ийн бүртгэл нь шууд тайлагнах эсвэл судалгаа явуулах замаар ТТ-ийн мэдээлэл цуглуулах зохион байгуулалтын үндсэн элемент юм.
- Зорилго: өмнө нь олон улсын үйлчилгээнд (эсвэл бусад ТТ-ийн гүйлгээ) гүйлгээ хийж байсан бүх резидент эдийн засгийн операторуудыг жагсаах.
- Хамрах хүрээ, судалгаанд оролцогчдын сонголтыг тодорхойлоход гол чухал үүрэгтэй.
- Бүртгэлийг **бүрэн дүүрэн, тогтмол шинэчилж байх ёстой** : аж ахуйн нэгжүүдийн хүн ам тогтворгүй байж болно.

Бизнесийн бүртгэлд юу багтдаг вэ?

- **Мэдээллийн хүрээ**
 - Тодорхойлолт, ангилал, холбоо барих болон нэмэлт мэдээлэл
- **Туслах хувьсагчид**
 - Эдийн засгийн хувьсагчид: эдийн засгийн эргэлт, эдийн засгийн үндсэн үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлт, төлбөрийн тэнцлийн хувьсагчид, гадаадын өмчлөлийн мэдээлэл, үйлчилгээний худалдаа (экспорт/импорт)
 - Аж ахуйн нэгжийг сонгох гол асуудал (хамрах хүрээ, хүрээний хэмжээг тодорхойлох).
- **Одоо байгаа бүртгэл (GBR, НӨАТ, худалдааны бүртгэлүүд...) болон бусад эх сурвалжуудыг (ОУГТС зэрэг) ашиглан ТТ-ийн бүртгэлийг бий болгож, шинэчилнэ.**

Бизнесийн бүртгэл гэж юу вэ?

- **Бизнесийн статистикийн ерөнхий бүртгэл**
 - Тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй бизнесүүдийн жагсаалт (дотоодын ба/эсвэл олон улсын)
 - Бизнесийн статистик болон бусад судалгаанд хүрээ гаргаж өгдөг.
- **Худалдааны бүртгэл**
 - Бараа бүтээгдэхүүний олон улсын худалдаанд оролцдог оршин суугч операторуудын жагсаалт
 - Үйлчилгээний худалдаатай холбоотой боломжит холбоо сүлжээ
- **НӨАТ-ын бүртгэл**
 - Татварын албанд өгсөн мэдээлэл
 - Үйлчилгээний худалдааны татвар
- **Төлбөр тооцооны мэдээллийн сан**
 - Банкны ОУГТС-ээс авсан олон улсын төлбөрийн мэдээллийн сан

Судалгаатай холбоотой тодорхой асуудлууд

- Аж ахуйн нэгжүүдийг зөв сонгох, эцсийн тооцооллын нарийвчлалыг нэмэгдүүлэхэд зориулагдсан **бүлэглэсэн хувьсагчид**.
- **Томоохон компаниудад** онцгой анхаарал хандуулах ёстой: ихэвчлэн 100% уу?
- Хамгийн жижиг компаниудад зориулсан **тодорхой шалгуур бүхий судалгааг** ашиглах уу? (өөрөөр хэлбэл 0%)
- Асуулга, аргачлалыг турших **туршилтын судалгаа**
- **Нарийвчилсан мэдээлэл, түүврийн хэмжээ**: Үйлчилгээний хэсгүүд болон газарзүйн задаргаа нь үнэн зөв тооцоо гаргахад хэт олон хувилбаруудыг гаргаж өгч болзошгүй.
- Судалгааны үр дүнг боловсруулж, судалгааны тооцоог **нэгтгэн гаргах**

4. Судалгаанд оролцогчдын өгсөн мэдээлэл

Гүйлгээ ба төлбөр тооцоо

- **ТТ болон ОУҮХС-ийн бүртгэлийн аль алинд нь гүйлгээний аргыг ашиглах шаардлагатай**
 - Үйлчилгээ үзүүлэх үед үйлчилгээний гүйлгээг бүртгэх шаардлагатай.
 - Энэ үед үйлчилгээтэй холбоотой төлбөрийн баримт, төлбөрийн хугацаа идэвхжсэн байдаг.
 - Төлбөр тооцоог олон үйлчилгээний гүйлгээний прокси гэж үзэж болно (хугацаа нь болоход төлнө).
- **Практикт энэ бүхэн нь тайлагналыг санхүүгийн хэлтэс гэхээсээ илүү аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн хэлтэс хийх шаардлагатай гэсэн үг юм.**

6. Аялал жуулчлалын үйлчилгээ

Аялал жуулчлалын үйлчилгээний боломжит эх үүсвэрүүд

- **Банкны ОУГТС**
 - Резидент бус/ Резидент аялагчид болон Резидент бус/ Резидент аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчдийн хоорондох мөнгөний урсгал.
 - Банкны мөнгөн тэмдэгт, аяллын чек эсвэл зээлийн картаар хийсэн төлбөрийн бүртгэл.
- **Судалгаа**
 - **Аялагчдын судалгаа** (эрэлт тал): хилийн судалгаа, өрхийн судалгаа.
 - **Аж ахуйн нэгжүүдийн судалгаа** (нийлүүлэлт тал): зочид буудлын судалгаа, жуулчдад зуучлагчдын судалгаа (аялал жуулчлалын агентлаг, тур операторууд).
 - Эдгээрийг хоёуланг нь физик хувьсагч (аялагчдын тоо) болон зардлыг (өнгөрөөсөн өдөр) хэмжихэд ашиглаж болно.
- **Түнш улсын мэдээлэл болон захиргааны эх сурвалж**

Аялал жуулчлалын үйлчилгээнд ОУГТС-ийг ашиглах нь

- **Давуу тал**
 - Хязгаарлагдмал зардал
 - Тогтмол давтамжтай мэдээлэл (сар бүр байж болно)
 - Цаг үеэ олсон байдал
 - Хамрах хүрээ: тооллого (нийт аялагч хүн ам).
- **Алдаа дутагдал**
 - Жуулчны бус гүйлгээг оруулах боломжтой
 - ОУГТС-д суурилсан газарзүйн хуваарилалт нь өрөөсгөл байж болно (валют=улс, доллар=АНУ)
 - Задаргааны түвшин бага: бизнесийг хувийн аялалаас салгахад хэцүү.

Аялал жуулчлалын үйлчилгээнд судалгааг ашиглах

- **Давуу тал**
 - Аялал жуулчлалтай холбоотой олон тооны хувьсагчийн талаар мэдээлэл өгөх боломжтой (зардлын зүйл, зориулалтын дэлгэрэнгүй мэдээлэл, түр байрлах хугацаа ...).
 - Гүйлгээ нь гадаадад байсан хугацаатай холбоотой тул цаг хугацаа зөв байна.
 - Гүйлгээ гаргагч талаас шууд мэдээллийг цуглуулдаг тул нийт урсгалын талаар мэдээлнэ гэсэн үг.
 - Зорилтот хүн амаас шууд судалгаа авдаг тул хамрах хүрээ сайн.
 - Түр байрлах зорилго тодорхой.
 - Газарзүйн байршил нь найдвартай (аялагчдын оршин суугаа улс).

Аялал жуулчлалын үйлчилгээнд судалгааг ашиглах

- **Алдаа дутагдал**
 - Түүврийн төлөөлөл бага байж болно (судалгааны зардал).
 - Түүвэр сонгох журам нь нарийн төвөгтэй байж болох бөгөөд түүврийн алдааг хянах шаардлагатай.
 - Хилийн судалгаа нь хил дамнах хязгаарлагдмал гарцтай орнуудад илүү тохиромжтой.
 - Зардал нь зөвхөн жилийн эсвэл хааяа судалгаа хийх боломжтой гэсэн үг юм.

Зардлын загварууд

- Практикт олон улс орнууд аялагчдын жишиг зардал эсвэл жилийн судалгаанд үндэслэсэн **зардлын загварыг** ашиглаж байна.
- Хамгийн энгийн загвар нь шилжилт хөдөлгөөний статистик мэдээллээс олж авсан дундаж зардал болон жуулчдын тоог үржүүлэх явдал юм.
- Сайжруулсан загварууд нь нэг хоногийн зардал, зорилго, орон сууцны төрөл, улс орны бүлгийг ашигладаг.

6. Дүгнэлт

Дүгнэлт

- **ОУҮХС-ийн мэдээлэл цуглуулах аргыг сонгох нь институци, эдийн засаг, практик үзүүлэлтээс хамаарна**
 - Англо-Саксоны орнууд хэсэг хугацаанд судалгааг ашиглаж байна.
- **Мэдээлэл цуглуулах арга нь тогтсон нэг арга байх албагүй**
 - Даяаршил нь өөрчлөлтийн нэг хүчин зүйл
- **Европын хувьд**
 - Банкны ОУГТС-ээс шууд тайлан/судалгааны систем
 - Өнөөдрийн байдлаар ОУҮХС-ийн мэдээлэл цуглуулах эрхийг ерөнхийдөө СХО-д өгсөн
 - Төв банкууд бүхэлдээ ТТ-ийн хариуцлагыг хүлээдэг

Баярлалаа